



2018 оны 11 дүгээр сар
(№19)

ОЛОН НИЙТИЙН ЦАГДААГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

(Өвөрхангай аймгийн Арвайхээр, Уянга сумдад)

МОНИТОРИНГИЙН ТУХАЙ

Нээлттэй Нийгэм Форум нь Өвөрхангай аймагт үйл ажиллагаа явуулдаг Орон нутгийн санаачилга ТББ-д “Өвөрхангай аймгийн Арвайхээр, Уянга сумын олон нийтийн цагдаагийн үйл ажиллагааны үр дүн” сэдвийн хүрээнд мониторинг хийх тэтгэлэг олгосон билээ. Өвөрхангай аймагт ажиллаж буй олон нийтийн цагдаагийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавьж, үйл ажиллагааны үр дүнг үнэлэх зорилгоор энэхүү мониторингийг хийв.

Мониторингийн дэлгэрэнгүй тайланг www.forum.mn цахим хуудаснаас үзнэ үү.

МОНИТОРИНГИЙН ДҮН

Өвөрхангай аймагт Цагдаагийн албаны тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.3-т заасан шаардлагад нийцсэн нийт 11 олон нийтийн цагдаа ажиллаж байна.

А. Хийж гүйцэтгэсэн ажлын дүн


Олон нийтийн цагдаа нь хуульд заасан эрх үүргийнхээ хүрээнд дор дурдсан ажил үүргийг гүйцэтгэжээ.

o Гэмт хэрэг, зөрчил гарсан газар, ул мөрийг хамгаалах чиглэлээр:

19 хэргийн газрын хамгаалалтад ажилласан

13759 иргэнд хууль тогтоомжийг тайлбарлан таниулсан

Хамтарч ажилласан хүний тоо



o Гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээдийг цагдаагийн байгууллагад хүргэх, хуульд заасан бол зөрчил үйлдсэн этгээдэд торгох шийтгэл оногдуулах чиглэлээр:

Цагдаагийн алба хаагчтай хамтран 2 гэмт хэрэг илрүүлсэн.


Зөрчил гаргасан 50 иргэнд 270000 төгрөгийн торгууль ногдуулсан.

Илрүүлсэн зөрчил



o Хэв журам сахих талаар иргэн, хуулийн этгээдэд шаардлага тавих талаар:

Албан байгууллагад хүргүүлсэн шаардлага



o Хууль тогтоомжийг иргэдэд сурталчлан таниулах талаар:

Ерөнхий боловсролын 30 сургуулийн 11852 сурагч, төрийн ба төрийн бус 12 байгууллагатай хамтран гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх уулзалт, өдөрлөг, сургалт зохион байгуулсан.

“School police”-ийн эргүүлээр ажилласан 1860 эцэг, эхэд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгсөн.

Иргэд болон 6500 аж ахуйн нэгжид гэмт хэргээс урьдчилан сэргийлэх 410 ширхэг санамж, сэрэмжлүүлэг тараасан.

- **Нийтийн хэв журам сахих талаар хууль сахиулах байгууллага болон бусад хуулийн этгээдээс зохион байгуулж байгаа ажилд оролцох чиглэлээр:**

Нийтийн хэв журам сахиулах хамгаалалтад 36 удаа гарч, цагдаагийн албан хаагчтай нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээнд 180 удаа хамтран ажилласан.

Ерөнхий боловсролын 10 сургууль орчмын авто зам, уулзвар, гарц хэсгүүдэд давхардсан тоогоор авто эргүүлийн 32, явган эргүүлийн 19 чиглэлд цагдаагийн алба хаагчтай хамтран хяналт тавьсан.

Б. Олон нийтийн цагдаагийн ажиллах нөхцөл, иргэдийн үнэлгээ

- Олон нийтийн цагдаагийн гүйцэтгэж буй ихэнх ажил үүрэг нь цагдаагийн алба хаагчийн ажилтай давцаж байгаа ч цалин урамшуулал хэт зөрүүтэй байгаа нь ажиглагдлаа.
- Олон нийтийн цагдаа нь хөдөлмөрийн аюулгүй байдлын тусгай хувцас, нэг бүрийн тусгай хэрэгслээр хангагдах ёстой. Өвөрхангай аймгийн хувьд олон нийтийн цагдаа нь хөдөлмөрийн аюулгүй байдлын тусгай хувцсаар бүрэн хангагдсан хэдий ч хувцасны чанар хангалтгүйгээс эдэлгээ даахгүй муудах нь түгээмэл байдаг ажээ. Эдэлгээний норм гүйцээгүй тул солих боломжгүй гэсэн хүндрэл тулгардаг байна.
- Олон нийтийн цагдаа ажилласнаар гэмт хэргийн гаралтыг бууруулах, нийгмийн хэв жуармыг сахиулахад ахиц гарч байгаатай цагдаагийн алба хаагч, иргэд санал нэг байна. Тухайлбал, “Аюулгүй хот-Цэвэр орчин” сэдэвт 3 сарын аяныг олон нийтийн цагдаа санаачлан хэрэгжүүлсэнд иргэд талархалтай байжээ. Энэ хүрээнд хог, угаадас асгасан, нохойгоо сул тавьсан өрхүүдэд сануулга өгч, алдаа дутагдлыг засуулах арга хэмжээ авсан нь иргэдэд хүрсэн ажил болжээ.
- Арвайхээр сумын 11 багийн 1450 иргэнээс авсан анкетын судалгаагаар оролцогчдын 55 хувь нь олон нийтийн цагдаагийн талаар мэддэгээ илэрхийлж, 62 хувь нь тэдний хувь нэмрийг сайн, маш сайн гэж

үнэлжээ. Харин 38 хувь нь олон нийтийн цагдаагийн үйл ажиллагааны үр дүнг сайн, маш сайн хэмээн хариулсан байна.

- **Олон нийтийн цагдаагийн үйл ажиллагааг ямар нэг байдлаар мэднэ хэмээн хариулсан 839 хүнээс авсан судалгааны дүн:**



- **Иргэдийн зүгээс олон нийтийн цагдаа ажиллуулах газруудыг тодорхойлсон байдал:**



ЗӨВЛӨМЖ

- Олон нийтийн цагдаагийн цалин урамшлыг нэмэх, хөдөлмөрийн аюулгүй байдлын тусгай хувцсыг эдэлгээ даахуйц чанартай болгох;
- Аймаг тус бүрээс олон нийтийн цагдаагийн үйл ажиллагаа, тусгай хувцас хэрэглэлд зарцуулагдах төсвийг төвлөрүүлж, ИТХ, Засаг даргын шийдвэрээр харьяа цагдаагийн газарт нь шилжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх;
- Олон нийтийн цагдаагийн урамшил, хувцас, тусгай хэрэгслийн хангамжийн мэдээллийг аймаг тус бүрээр нэгтгэж, аймгийн Засаг дарга нарт хүргүүлэх, энэ чиглэлээр харилцан туршлага солилцох боломжийг бүрдүүлэх;
- Нутаг дэвсгэрийн цагдаагийн газар нь олон нийтийн цагдаагийн хэрэгцээ зайлшгүй шаардлагатай байгаа сумдад хүн хүч нэмэгдүүлэхэд хүчин чармайлт идэвх зүтгэлтэй ажиллах;
- Олон нийтийн цагдаагийн ажлыг дүгнэх шалгуур үзүүлэлтийг илүү боловсронгуй болгох, хамт олны үнэлгээ, иргэд олон нийтийн сэтгэл ханамжийн үнэлгээг үүнд үзүүлэлт болгох боломжийг судлах;
- Нутгийн өөрөө удирдах байгууллага нь олон нийтийн цагдаагийн ажиллах нөхцөлийг сайжруулахад шаардлагатай төсөв хөрөнгийг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллахыг зөвлөмж болгож байна.



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

Жамьян гүний гудамж -5/1,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар - 14240,
Утас: (976-11) 313207
Факс: (976-11) 324857

Энэ дугаарт Өвөрхангай аймагт үйл ажиллагаа явуулдаг Орон нутгийн санаачилга ТББ-аас Өвөрхангай аймгийн Арвайхээр, Уянга сумын олон нийтийн цагдаагийн үйл ажиллагаанд хийсэн мониторингийн үр дүнг нийтлэв. Энэхүү мониторинг нь Орон нутгийн санаачилга ТББ-аас ирүүлсэн сэдвийн хүрээнд ННФ-ын санхүүжилт болон арга зүйн дэмжлэгтэйгээр хийгдсэн болно.